




РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ОНЦЛОХ 21 ҮЙЛ ЯВДАЛ

2021





**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ
УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
2021 ОНЫ ОНЦЛОХ 21 ҮЙЛ ЯВДАЛ**

PRODUCTION



РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Алсын хараа

Тэргүүлэх түвшний
нээлттэй сургууль байх

Эрхэм зорилго

Иргэнд хөдөлмөрийн зах зээлийн
эрэлтэд нийцсэн чадамжид
суурилсан, мэдээллийн
технологит тулгуурласан насан
туршийн боловсрол, сургалтын
үйлчилгээ үзүүлэх

Хөгжлийн зорилтууд

Нээлттэй, цахим, ногоон сургууль



1

Сургуулийг 2021-2025 онд хөгжүүлэх **“СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ”**-г боловсруулж, удирдах зөвлөлөөр батлуулав. Бид шинэ алсын хараа, шинэ эрхэм зорилгыг хэрэгжүүлэх гараагаа эхлүүлээ.

2

Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж, БМИҮЗ-өөр **ҮСЧИН, ГОО ЗАСАЛЧ, ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЁДОЛЧИН, ҮСЧНИЙ ТЕХНОЛОГИЧ** мэргэжлийн хөтөлбөрүүдийг жилээр МАГАДЛУУЛСАН.



3

3 шатны **“СУРГАЛТЫН, ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ”**-г иж бүрэн шинэчилж, техникийн боловсрол олгох сургалтын хүртээмжийг нэмэгдүүлсэн.



4

СУРГУУЛИЙН ДҮРЭМ,
ЖУРАМ болон 33 мэргэжлийн
“АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ
ШИНЭЧЛЭВ.




5

БАГШ НАРЫН УР ЧАДВАРЫН ТҮВШИН,
цагийн ачааллыг тогтоох үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.
Багшийн ур чадварын түвшин 37,8%-иар өссөн амжилттай байна.







6

Цахим сургалтын оновчтой төлөвлөж, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах **“ЦАХИМ СУРГАЛТЫН ТӨВ”**, сургалт удирдлагын **“ЦАХИМ СУРГУУЛЬ”** систем, сургалтын хөтөлбөрт зөвхөн цахимаар орох нэгж, сэдвүүдийг тодорхойлох зэрэг томоохон шинэчлэлийг хийлээ.



7

Ажил олгогчийн захиалгаар **“ГУТЛЫН ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН”, “АНГИЙН ҮС, ҮСЛЭГ ЭДЛЭЛ, АРС САНХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЁДОЛЧИН”** мэргэжлийг шинээр нээв.



“ИНТЕРПРЕНЕР БАГШ-2021”

багш нарын бүтээлч үйл ажиллагааг түгээн дэлгэрүүллээ. Багш Э.Түвшин, Д.Энхсаруул, үсчин мэргэжлийн багш нарын бүтээлүүдийг онцлон ХНХЯ-ны МБСБХЗГ-тай хамтран улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн.

8



PRODUCTION

УҮҮҮГ-НИЙ УРЛА

"НИЙН САЛГАГАА НАВХААДШУУЙ
НООД ХОЖЛИЙН БОЛОМЖ БОЛОГӨ"

ЭН ХҮЙН ХӨХӨӨНИЙН ДИЙНИЙ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛААГАА

ЦАХИМ СҮРГУУЛИЙН СИСТЕМ



[illegible][illegible]

МБСБ-уудын багш нарын **ЗААХ АРГЫН БҮСИЙН БОЛОН УЛСЫН УРАЛДААНД** ТЭРГҮҮН, ДЭД БАЙР-уудыг эзэллээ. Багш Д.Нинжбадгар - Тэргүүн байр, багш Н.Алтансувд- дэд байрыг эзэлсэн амжилтыг үзүүллээ.

9



ШИЛДЭГ АРГА
ЗҮЙТЭЙ БАГШ
2021

УЛСЫН УРАЛДААН
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ, ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН БАГШ НАР

2021-04-23



10

МБСБ-уудын инновацийн уралдаанд шилдэг номинациудыг хүртлээ. Багш П.Чулуунбат, Д.Ганболд нарын “Лед самбар” бүтээл **“БАГШ СУРАЛЦАГЧИЙН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛСЭН БҮТЭЭЛ”** номинацийг, багш Д.Энхсаруул багшийн “Баатар” бүтээл нь “ШИЛДЭГ ТЕХНОЛОГИ ШИНГЭСЭН БҮТЭЭЛ” номинацийг түс түс хүртлээ.

[illegible]

PRODUCTION

AT

БААТАР
БАГШИН
МЭРГЭЖЛИЙН
УЙДЭВЭРЭЛ УУРЛАЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛВАРЫН

**ИННОВАЦИ ШИНГЭСЭН
БҮТЭЭЛ**

БҮТЭЭЛИЙН НЭР: БААТАР
БАГШИН НЭР: С.ХИХСҮРҮЛ
МЭРГЭЖЛИЙН НЭР: БЭЛЭГ ДУРСГАЛ

УУЛАН-БААТАР ХОТ
2021 он

11



МБСБ-уудын **УЛСЫН ИЛТГЭЛИЙН УРАЛДААН**-д сургалтын алба багаараа орж **ДЭД БАЙР**-ыг эзэллээ. Сургалтын албаны менежер Б.Мядагбадам, сургалтын арга зүйч И.Оюунчимэг, тэнхимийн эрхлэгч Б.Анхбаяр нар хамтран “Цахим сургууль сургалт удирдлагын системийн үр дүн” сэдэвт илтгэлийг амжилттай хэлэлцүүлэн дэд байрын шагнал хүртсэн.

Тогоочийн мэргэжлээр **“МОНГОЛ УР ЧАДВАР”**-2021 ур чадварын уралдаанд 1, 2-р шатанд тус бүр 2-р байр эзэлсэн амжилттай оролцож, багш С.Цэнд-Аюуш 2022 оны 10 дугаар сард БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдах Дэлхийн ур чадварын 46 дах удаагийн тэмцээнд Монгол улсаа төлөөлөн эксперт багшаар оролцохоор шалгарлаа.

12



13

НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ, СУДАЛГАА ИННОВАЦИ цахим сэтгүүлийг гаргаж, олон нийтэд судалгаа, инновацийн бүтээлүүдээ сурталчиллаа.

НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ ИННОВАЦИ

УУПК-ийн УРИА:

“ШИНЭ САНААГАА ШАВХАГДАШГҮЙ НӨӨЦ, ХӨГЖЛИЙН БОЛОМЖ БОЛГО”






НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ, СУДАЛГАА ИННОВАЦИ

УРИА: ШИНЭ САНААГАА ШАВХАГДАШГҮЙ НӨӨЦ, ХӨГЖЛИЙН БОЛОМЖ БОЛГО

14

Жилийн **ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН**-ийн хяналтыг шалгасан хараат бус аудитын байгууллагын шалгалтад акт, албан шаардлага тавиулаагүй ажилласан байна. Сургуулийн **“ӨӨРИЙН ОРЛОГО”**-ыг 134 хувиар давуулан биелүүлж, багш ажилтны нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэв.



Мэргэжлийн 2 тэнхимийн багш нарын өрөөг бий болгож засварлаж, тохижуулав. Ажлын байрны ая тухтай нөхцөлийг хангаснаар олон амжилт, бүтээлийг хийх боломжтой боллоо.

15

“БАГШ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛ”-ийг сайжруулж, сургуулийн тохижилт үйлчилгээ, засварыг сургуулийн захиргаа, үйлчилгээний хамт олон өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэсэн болно.



2020 ОНЫ ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Оюутан суралцагчдын төлөөлөл болж тэдний эрх ашгийг хамгаалах, хөгжих нөхцөлийг бүрдүүлэн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Оюутны зөвлөл нь 15 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилд

Зөвлөлийн даргаар Үс заслын технологич 1а Б.Мөнхзул,

Нарийн бичгээр Вэб мульт медиа зохиогч 1а Б.Номундарь,

Зөвлөлийн гишүүдээр

- Гоо засалч 2а Б.Хичээнгүй,
- Өгөгдлийн сангийн операторч 2б М.Сарангэрэл,
- Өгөгдлийн сангийн операторч 1а П. Содбаяр,
- Зочид буудал жуулчны баазын үйлчилгээний ажилтан М.Анужин
- Үс заслын технологич 1а Б.Биндэръяа,
- Өгөгдлийн сангийн операторч 1б У.Сайнбат,
- Тогооч 2а Б.Гарьд
- Хөвлөлийн график дизайнерч 1а Т.Төрбадрал,
- Нарийн бичгийн дарга албан хэргийн ажилтан 1а Г.Энхжин,
- Автомашин засварчин 1а Б.Батбаяр,
- Тогооч 1б С.Баяртнаран
- Тогооч 1а О.Ган-Эрдэнэ
- Үсчин 1б Б.Лхагвасүрэн

16

Оюутан суралцагчид, төгсөгчдийн оролцооны байгууллагуудын бие даан ажиллах нөхцөлийг шинэчлэн бүрдүүллээ. Ингэснээр **ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО** зэрэг өөрийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрсэн.

17

БОЛОВСРОЛЫН ТҮНШЛЭЛ-ийг өргөжүүлэх ажлыг амжилттай буухиалж, Сити, ШУТИС, МУБИС, Хүрээ МТДС, Кён-Ин-ий их сургууль, ТТДС, Архангай МСҮТ, Хөвсгөл ПК, Хэнтий ПК, Баянхонгор ПК, Дорнод ПК зэрэг сургалтын байгууллагуудтай хамтран ажиллалаа.



Ражив Гандийн Нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж

March 3 at 2:32 PM · 🌐

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Сургуулиудын хамтын ажиллагаа, манлайлал, хувийн хэвшлийн манлайлалыг үүсгэхээр анх удаа нэг зүгт сургуулиуд хамтран мехатроник мэргэжлийн чиглэлээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангахаар санамж бичиг байгууллаа.

Төгсөлтийн үнэлгээг түншлэлд тулгуурлан үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад хийж хэвшүүлж байна. Ингэснээр **ТӨГСӨГЧ-АЖЛЫН БАЙР-ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ** асуудлыг шийдвэрлэх боломж нээгдлээ.

18



19

Мэргэжлийн боловсрол олгох сургалтыг 619 хүүхэд төгссөний 60 гаруй хувь нь түншлэгч байгууллагуудаас **“АЖИЛД ОРОХ УРИЛГА”** гардан авсан сайхан үйл явдал боллоо. Мөн төгсөгчдийн 20 хувь нь техникийн боловсрол олгох сургалтад дэвшин суралцахаар саналаа өгсөн байна.



20

Улаанбаатар бүсийн МБСБ-уудаас **“ХАБЭА ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА”**-аар шалгарч улсад тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүллээ.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙН ТӨВ
April 28, 2021 · 0

“ХАМГААС ТҮРҮҮНД ХАБЭА” УРИАТАЙ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯНАА ДҮГНЭВ

МБСҮМАЗТөвөөс Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2021” аяныг “Хамгаас түрүүнд ХАБЭА” уриатайгаар 4 дүгээр сарын 1-28 ны хооронд зохион байгуулж өнөөдөр дүгнэлээ.

Аяны хүрээнд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дадал хэвшлийг сайжруулах хүрээнд хууль журмын хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан” бэлтгэж буй сургалтын байгууллагын сургалт, үнэлгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор 5 удаагийн сургалт хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгууллаа.

МБСҮМАЗТ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд тодорхой арга хэмжээг зохион байгуулж, туршлага мэдлэгээсээ хуваалцан, ХАБЭА-н зааварчилгааг түгээн дэлгэрүүлж идэвхтэй оролцлоо.

Аянг дүгнэх арга хэмжээний үеэр Дорнод аймаг дахь Политехник коллеж, Дархан-Уул аймаг дахь Уул уурхайн, эрчим хүчний политехник коллеж, Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж, Дундговь аймаг дахь МСҮТ, Үйлдвэрлэл урлалын политехник коллеж гэсэн таван сургууль ХАБЭА-н шилдэг туршлагаасаа хуваалцсан юм.

Идэх санаачилгатай оролцсон таван сургуульд МБСҮМАЗТ-өөс батламж гардууллаа.

“Хамгаас түрүүнд ХАБЭА” уриатай сарын аяныг дүгнэж МБСҮМАЗТ-ийн дарга Ц.Батдорж хэлсэн үгэндээ, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй нь хүний амь нас эрүүл мэнд, амьдралын чанартай холбоотой чухал асуудал учраас сарын аяны хүрээнд яриад орхих биш олж авсан сайн туршлага мэдлэгээ түгээн дэлгэрүүлж, бүх цаг үед хамгаас түрүүнд ХАБЭА-н зааварчилгааг мөрдөх, суралцагчдад ийм дадал хэвшлийг маш сайн суулгаж өгөх хэрэгтэй”-г онцоллоо.

Хаалтын арга хэмжээнд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд, мэргэжлийн зөвлөл, холбоод, олгогчдын төлөөлөл болох 250 гаруй хүн оролцлоо.

#ХамгаасТүрүүндХАБЭА

ХӨДӨЛМӨР
НИЙГЭМНИЙ ХАМГААЛЛЫН ЯАМ

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ,
АРГА ЗҮЙН ТӨВ



мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын
хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн
САРЫН АЯН

21

Ковид-19 цар тахлын гамшгийг хамт олноороо даван туулж, олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, нийт суралцагчид, дотуур байрны суралцагчдын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшин **“ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЯН”**-д нэгдэн 3-р тунд 90 ХУВЬ хамрагдсан байна.



2021 ОНЫ ОНЦЛОХ 21 ҮЙЛ ЯВДАЛ



Иргэнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн чадамжид суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан насан туршийн боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилгын хүрээнд зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж 2021 оны онцлох 21 ажлыг та бүхэн танилцууллаа.



САНААЧИЛАН БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР Б.МЯДАГБАДАМ
ЭХ БЭЛТГЭСЭН: Д.НИНЖБАДГАР
ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛСЭН: Э.ТҮВШИН

